

**БАТЛАВ.**

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны  
Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн  
газрын дарга

Г.ЭНХМӨНХ

“Эко Драйволл” ХХК-ийн  
Гүйцэтгэх захирал

Б.АНХБАЯР

**Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт орших  
“Тарагт-1” нэртэй гөлтгөнийн ордыг ил аргаар ашиглах  
төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 7004265

**ХЯНАСАН:**

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн  
яамны Хүрээлэн буй орчны бодлогын  
хэрэгжилтийн газрын мэргэжилтэн

: .....

**БОЛОВСРУУЛСАН:**

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН:

Х.МӨНГӨНБААТАР

Улаанбаатар хот

2026 он

## **ОРШИЛ**

Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний эрх бүхий Евро Азиа Эко “ХХК-аар Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт орших “Эко Драйволл” ХХК-ийн “Тарагт-1” нэртэй гөлтгөнийн ордыг ил аргаар ашиглах төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийж гүйцэтгүүлсэн ба мэргэжил арга зүйн зөвлөгөө авсны үндсэн дээр 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажлыг хийж гүйцэтгэлээ.

Энэхүү ажлыг гүйцэтгэхдээ “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай”, “Усны тухай” хуулиуд, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-05 дугаар тушаалаар баталсан Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” болон Байгаль орчин, аялал жуулчлалын яамны шинжээчийн гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлт, нарийвчилсан үнэлгээ зэргийг үндэс болгов.

Төслийн гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тодорхойлох, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлыг төлөвлөх, үйлдвэрийн бүх шат дамжлага бүрд нөлөөлөл бууруулах зөвлөмж боловсруулах, үйл ажиллагааны явцад мөрдөж ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр боловсруулах зэрэг нь зайлшгүй шаардлагатай юм.

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА БОЛОН ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ

### 1.1 Төслийн ерөнхий мэдээлэл:

**Төслийн нэр:** “Тарагт-1” нэртэй гөлтгөнийн ордыг ил аргаар ашиглах төсөл.

**Төслийн зорилго:** “Эко Драйволл” ХХК нь орд газрыг бүрэн дүүрэн ашиглах зорилтын хүрээнд ашиглалтын MV-000251 тоот тусгай зөвшөөрлийн талбайн ил уурхайн хүрээнд өртөж буй гөлтгөнийг олборлон эдийн засгийн эргэлтэд оруулж, Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль дүрмийн хүрээнд аюул осолгүй, үйлдвэрлэл явуулж, үнэ цэнэ, ач холбогдлыг нэмэгдүүлэх, ашиглалтын зардлыг боломжит бага хэмжээнд байлгаж, Монгол Улсын төсвийн бүрдүүлэлт, татварын нэр төрлийг нэмэгдүүлж, орд газрын үр өгөөжийг нэмэгдүүлэхэд энэхүү төслийн зорилго оршино.

### **Компанийн нэр, товч мэдээлэл:**


“Эко Драйволл” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9011862560, Регистрийн дугаар: 7004265, Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл: MV-000251.

### **Компанийн товч танилцуулга:**

“Эко Драйволл” ХХК нь “Ашигт малтмалын тухай” хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, ордод ашиглалтын үйл ажиллагаа явуулах, дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Тус компани үйл ажиллагааны дараах үндсэн чиглэлтэй. Үүнд:

- ✓ Барилгын материалын худалдаа
- ✓ Цаас болон цаасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл
- ✓ Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа
- ✓ Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх



Зураг 1. Төслийн талбайн байршил

Хүснэгт 1. Төслийн талбайн солбицол

№	X (UTM48N)	Y (UTM48N)	Өргөрөг (WGS-84)			Уртраг (WGS-84)		
			град	мин	сек	град	мин	сек
1	4987593.63	460644.11	45	2	26.54	104	30	1.09
2	4988519.46	460649.82	45	2	56.54	104	30	1.09
3	4988526.14	459728.92	45	2	56.57	104	29	18.99
4	4987600.71	459723.07	45	2	26.58	104	29	18.99

### Уурхайн хүчин чадал

Ордыг 7 жилийн хугацаанд ашиглахаар төлөвлөсөн. Ордын техникийн нөхөн сэргээлтийг ашиглалтын 7 жилд багтаан хийж гүйцэтгэнэ.

Уурхайгаас гарах гөлтгөнийг “Эко Драйволл” ХХК нь Монгол Улсын дотооддоо үйлдвэрлэх гипсэн хавтангийн гол түүхий эдийн хэрэгцээнд ашиглана жилийн хүчин чадал нь жилд 70.0 мян.тн байна.

### 1.2 Ашиглалтын системийн сонголт

Ордын уул-геологи, уул-техникийн нөхцөлөөс нь хамааруулан уурхайг авто тээвэртэй гадаад, дотоод овоолготой ашиглалтын системээр ашиглахаар сонгов. Энд ордын ашигт малтмалын зузаан, хөрсний зузаан, газарзүйн байрлал, хөрсний

чулуулгийн шинж чанар зэргийг харгалзана. Олборлолт, хөрс хуулалтын ажлыг нөөцийн блокийн өргөнтэй тэнцүү өргөнтэй, 60-100 метрийн урттай блокууд үүсгэн явуулна. “Тарагт-1”-ын гөлтгөний ордын хөрсний давхарга нь харьцангуй нимгэн ба ихэнх тохиолдолд өнгөн шимт хөрс зонхилж байна. Энэ тохиолдолд хөрс хуулалтын технологийг дан экскаватор утгуурт ачигчийн хослолоор хуулах боломжтой юм. Ил уурхайн хэлбэр, хэмжээ, чулуулгийн технологийн шинж чанар зэрэг суурь нөхцөлүүдийг үндэслэн дараах механикжуулалтын бүтцийг хөрс хуулалт, олборлолтын ажилд тохиромжтой гэж үзэж байна.

Орд нь харьцангуй тэгш гадаргуутай, хөрсний зузаан бага, ашигт давхарга нь дунджаар 2.96 м, ерөнхийдөө тогтвортой зузаантай, бараг хэвтээ уналтай.

“Тарагт-1” гөлтгөнийн ордын гадаргуу нь харьцангуй тэгш (өндөржилтийн зөрүү 1165- 1180м). Гөлтгөнийн ашигт давхарга хэвтээ байрлалтай. Хөрсний чулуулаг нь шавранцар болон элсэнцэр ба шавраас тогтох бөгөөд 1.2-1.9 м, дунджаар 1.5 м,

Хучаас болон ашигт давхарга нь литологийн хувьд сэвсгэр буюу маш сул барьцалдсан хэмхдэст хурдас тул хөрс хуулах болон ашигт давхаргыг олборлох үед өрөмдлөг тэсэлгээний ажил шаардагдахгүй, экскаватороор шууд ухаж ачих боломжтой.

Олборлолтын ажлыг ордын урд хэсгээс буюу гөлтгөнийн давхарга гадаргууд ил гарсан хэсгээс эхлэн ашигт давхаргын ерөнхий суналд хөндлөн чиглэлд уурхайлах бөгөөд өмнөд хэсэг дэх бага хэмжээний хучаас чулуулгийг ашиглагдсан орон зайд дотоод овоолго үүсгэх замаар нөхөн сэргээлтийн ажлыг олборлолтын ажилтай хамт гүйцэтгэнэ. Байгалийн болон уул техникийн хүндрэл харьцангуй бага газрын гадаргад ойр.

Дээрх уул геологийн нөхцөлийг үндэслэн ордыг ил уурхайн аргаар авто тээвэртэй ашиглалтын системээр ашиглахаар төсөлд тусгалаа. Ордын тогтцоос хамааран хөрсийг гадаад болон дотоод овоолгод тээвэрлэн түр овоолго үүсгэнэ.

***Хүснэгт 2. Уулын ажлын тоног төхөөрөмжийн хослолын бүрдэл***

№	Ажил	Процессууд (тоног төхөөрөмж)			
1	Хөрс хуулалт	Ухаж түрэх	Овоолго		
		Экскаватор	Экскаватор		
		Утгуурт ачигч	Утгуурт ачигч		
2	Гөлтгөнө олборлолт	Экскавац	Тээвэр	Хатаах, овоолох	Дахин ачилт
		Экскаватор	Автосамосвал	Шигшүүр	Утгуурт ачигч


**1.3 Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө**

Уурхайн олборлолтын үйл ажиллагаа жилд 70.0 мян.тн гөлтгөнө олборлож хөрс хуулалтын дундаж итгэлцүүрийг ил уурхайн оновчлолын дагуу дунджаар 0.6 м<sup>3</sup>/м<sup>3</sup>-д барихаар төлөвлөж уулын ажлын календарчилсан төлөвлөлтийг хийж гүйцэтгэсэн.

*Сонгинохайрхан дүүргийн 32-р хорооны нутагт орших “Ариутгал, шавж устгалын үйлчилгээнд хэрэглэх бодис хадгалах агуулах” төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө*

**Хүснэгт 3. Ил уурхайн уулын ажлын календарьчилсан төлөвлөлт**

Блоккийн дугаар	Хөрс хуулах талбай	Шимт хөрсний зузаан	Хөрс хуулалт	Шимт хөрс хуулалт	Нийт хөрс хуулалт	Гөлтгөний нөөц мян.м <sup>3</sup>	Ашигт давхаргаас гарах гөлтгөний гарц кг/м <sup>3</sup>	Гөлтгөний нөөц мян.тн	Уулын цулаар	Хөрс хуулалтын дундаж коэффициент
Хэмжих нэгж	мян.м <sup>2</sup>	м	мян.м <sup>3</sup>	мян.м <sup>3</sup>	мян.м <sup>3</sup>	мян.м <sup>3</sup>	%	мян.тн	м <sup>3</sup>	м <sup>3</sup> /м <sup>3</sup>
<b>Ашиглалтын 1-р жил</b>										
I-3В	24.73	0.10	38.40	2.47	40.87	71.53	334.27	23.91	112.41	0.57
I-4В	13.05	0.10	7.57	1.30	8.88	31.71	429.32	13.61	40.59	0.28
I-4С	10.34	0.10	7.37	1.03	8.41	23.29	331.12	7.71	31.70	0.36
I-6С	14.15	0.10	10.66	1.42	12.07	43.29	378.30	16.37	55.36	0.28
I-7С	7.11	0.10	27.43	0.71	28.15	20.83	402.82	8.39	48.97	1.35
<b>НИЙТ</b>	<b>69.37</b>	<b>0.10</b>	<b>91.44</b>	<b>6.94</b>	<b>98.38</b>	<b>190.65</b>	<b>367.18</b>	<b>70.00</b>	<b>289.03</b>	<b>0.52</b>
<b>Ашиглалтын 2-р жил</b>										
I-1А	16.72	0.10	7.34	1.67	9.01	42.46	413.12	17.54	51.47	0.21
I-1В	7.20	0.10	8.45	0.72	9.17	24.87	356.06	8.85	34.04	0.37
I-1С	0.89	0.10	0.95	0.09	1.04	2.17	249.60	0.54	3.21	0.48
I-5С	18.58	0.10	4.15	1.86	6.01	40.05	399.33	16.00	46.07	0.15
I-7С	24.68	0.10	55.13	2.47	57.59	67.20	402.82	27.07	124.79	0.86
<b>НИЙТ</b>	<b>68.07</b>	<b>0.10</b>	<b>76.02</b>	<b>6.81</b>	<b>82.82</b>	<b>176.75</b>	<b>396.04</b>	<b>70.00</b>	<b>259.58</b>	<b>0.47</b>
<b>Ашиглалтын 3-р жил</b>										
I-1В	33.48	0.10	39.30	3.35	42.65	115.62	356.06	41.17	158.27	0.37
I-2В	0.10	0.10	0.10	0.01	0.11	0.33	364.71	0.12	0.44	0.33
I-1С	10.44	0.10	10.54	1.04	11.59	25.36	249.60	6.33	36.95	0.46
I-7С	9.32	0.10	21.55	0.93	22.48	25.47	402.82	10.26	47.96	0.88
I-8С	8.75	0.10	26.22	0.88	27.10	28.76	421.50	12.12	55.85	0.94
<b>НИЙТ</b>	<b>62.09</b>	<b>0.10</b>	<b>97.71</b>	<b>6.21</b>	<b>103.92</b>	<b>195.54</b>	<b>357.98</b>	<b>70.00</b>	<b>299.47</b>	<b>0.53</b>
<b>Ашиглалтын 4-р жил</b>										
I-2В	18.85	0.10	18.78	1.89	20.67	62.14	364.71	22.66	82.81	0.33
I-8С	34.17	0.10	102.40	3.42	105.81	112.31	421.50	47.34	218.12	0.94
<b>НИЙТ</b>	<b>53.02</b>	<b>0.10</b>	<b>121.18</b>	<b>5.30</b>	<b>126.48</b>	<b>174.44</b>	<b>401.27</b>	<b>70.00</b>	<b>300.93</b>	<b>0.73</b>
<b>Ашиглалтын 5-р жил</b>										
I-8С	48.73	0.10	198.82	4.87	203.69	166.09	421.50	70.00	369.77	1.23
<b>НИЙТ</b>	<b>48.73</b>	<b>0.10</b>	<b>198.82</b>	<b>4.87</b>	<b>203.69</b>	<b>166.09</b>	<b>421.50</b>	<b>70.00</b>	<b>369.77</b>	<b>1.23</b>
<b>Ашиглалтын 6-р жил</b>										
I-2В	39.14	0.10	40.87	3.91	44.79	129.46	364.71	47.22	174.25	0.35
I-2С	8.83	0.10	13.70	0.88	14.59	31.76	353.78	11.23	46.34	0.46
I-8С	8.33	0.10	24.97	0.83	25.80	27.39	421.50	11.54	53.19	0.94
<b>НИЙТ</b>	<b>56.30</b>	<b>0.10</b>	<b>79.55</b>	<b>5.63</b>	<b>85.18</b>	<b>188.61</b>	<b>371.12</b>	<b>70.00</b>	<b>273.78</b>	<b>0.45</b>
<b>Ашиглалтын 7-р жил</b>										
I-2В	37.84	0.10	37.70	3.78	41.49	124.72	364.71	45.49	166.21	0.33
I-3С	12.60	0.10	15.77	1.26	17.03	53.58	344.75	18.47	70.61	0.32
<b>НИЙТ</b>	<b>50.44</b>	<b>0.10</b>	<b>53.47</b>	<b>5.04</b>	<b>58.51</b>	<b>178.30</b>	<b>358.71</b>	<b>63.96</b>	<b>236.82</b>	<b>0.33</b>
<b>БҮГД</b>	<b>408.02</b>	<b>0.10</b>	<b>718.18</b>	<b>40.80</b>	<b>758.98</b>	<b>1,270.39</b>	<b>380.96</b>	<b>483.96</b>	<b>2,029.37</b>	<b>0.60</b>



Зураг 2. 2026 онд олборлолт явуулах талбай

Эхний жилд хуулах хөрсийг уурхайн хажууг дагуулан захилах хэлбэрээр овоолохоор төлөвлөсөн. Эхний жилийн хөрс хуулалтын дундаж итгэлцүүр  $0.47 \text{ м}^3/\text{м}^3$  байна. Уурхайгаас олборлох гөлтгөнийг уурхайгаас 1 км зайтай цехийн талбай руу тээвэрлэхээр төлөвлөсөн.

#### 1.4 Ил уурхайн процесс

“Тарагт-1”-ын гөлтгөний ордыг ил аргаар ашиглах ТЭЗҮ-д ил уурхайг авто тээвэртэй, хөрсний гадаад дотоод овоолготой ашиглалтын системээр ашиглахаар ТЭЗҮ-д тусгасан. Тоног төхөөрөмжийн хүчин чадал болон ил уурхайн ашиглалтын системийн элементийн үзүүлэлтүүдийг үзүүлэв.

Хүснэгт 4. Ашиглалтын системийн элементийн үзүүлэлтүүд

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Уурхайн ажлын доголын өндөр	м	6
2	Ажлын доголын хажуугийн өнцөг	град	50
3	Тээврийн траншейн өргөн	м	10
4	Ажлын талбайн хамгийн бага өргөн	м	22

##### 1.4.1 Шимт хөрсийг хуулах

Шимт хөрсийг Luigong-856 маркийн утгуурт ачигчаар хуулж, уурхайн хажууг дагуулж шимт хөрсний овоолгод хураана. Шимт хөрсний овоолгыг 2 метрийн өндөртэй, 30 градусын налуутайгаар байгуулна. Шимт хөрсийг уурхай, овоолгын суурийн талбайгаас 0.1 метрийн зузаантайгаар хуулна. Нийтдээ  $40.8 \text{ мян.м}^3$  шимт хөрсийг хуулж овоолно. Шимт хөрсийг утгуурт ачигчаар түрж шилжүүлэх ажлын

бүтээлийн тооцоог гүйцэтгэж, тооцооны үндсэн үзүүлэлтүүдийг дараах хүснэгт-д үзүүлэв.

**Хүснэгт 5. Шимт хөрсийг хуулах ажилд ажиллах Liugong 856 маркийн утгуурт ачигчийн техникийн тодорхойлолт**

№	Үзүүлэлт	Х.нэг ж	Утга
1	Дугуйт ачигчийн марк		Liugong -856
2	Утгуурын багтаамж	м <sup>3</sup>	3
3	Өөрийн жин	тн	24.5
4	Зүтгэх хүч	кН	218
5	Асгалтын хамгийн их өндөр	м	3.15
6	Урт	м	9.11
7	Өргөн	м	2.96
8	Өндөр	м	3.6
9	Эргэлтийн радиус	м	7.2
10	Дээд хурд	км/ц	36.5
11	Шатахууны савны хэмжээ	л	410
12	Дугуйн тоо	ш	4
13	Дугуйн марк	-	26.5-R25



**Хүснэгт 6. Шимт хөрсийг хуулах ажилд ажиллах шаардлагатай утгуурт ачигчийн, ажиллах цаг**

Ашиглалтын жилүүд	Шимт хөрс хуулалт	Утгуурт ачигчийн жилийн бүтээл	Шаардлагатай утгуурт ачигчийн тоо /тооцооны/	Нөөцийн итгэлцүүр	Шаардлагатай утгуурт ачигчийн тоо /бодит/	Жилд ажиллах цаг
Х.нэгж	мян.м <sup>3</sup> /жил	мян.м <sup>3</sup> /жил	ш		ш	мото.цаг
1-р жил	8.32	424.55	0.02	1.2	1	42.35
2-р жил	8.17	424.55	0.02	1.2	1	41.56
3-р жил	7.45	424.55	0.02	1.2	1	37.91
4-р жил	6.36	424.55	0.02	1.2	1	32.37
5-р жил	5.85	424.55	0.02	1.2	1	29.75
6-р жил	6.76	424.55	0.02	1.2	1	34.38
7-р жил	6.05	424.55	0.02	1.2	1	30.79
<b>НИЙТ</b>	<b>48.96</b>	<b>424.55</b>		<b>1.2</b>	<b>1</b>	<b>249.11</b>

### 1.4.3 Тээврийн хэрэгслийн тоног төхөөрөмжийн сонголт, бүтээлийн тооцоо

Уурхайн гөлтгөнө тээвэрлэлтийн ажилд 30 тн даацтай Northbenz ND3315маркийн автосамосвал ашиглахаар төсөлд тусгасан. Уурхайгаас олборлосон гөлтгөнийг 30 тн даацтай Northbenz ND3315маркийн автосамосвалаар тээвэрлэн гөлтгөнө хүлээн авах, нөөцлөх талбайд буулгах бөгөөд дотоод тээврийн замын урт ашиглалтын улирлуудад харилцан адилгүй байх ба уурхай тэлэх, тээврийн замын урт нэмэгдэхтэй холбоотойгоор нэг талдаа 1.0-1.8 км зайтай байна. Уурхайн хөрс болон гөлтгөнийн тээвэрлэлтийн механикжуулалтын ажлыг автосамосвалын тусламжтай

гүйцэтгэнэ. Гөлтгөнийг автосамосвалаар тээвэрлэн уурхайгаас баруун 1.0-1.8 км ийн зайд байрлах уриншлах талбай руу тээвэрлэн овоолго үүсгэн, уриншлан бэлтгэсэн гөлтгөнийг шигшин ангилах хэсэгт гөлтгөнийн агуулахад хураана. Гөлтгөнийг тээвэрлэн очсон автосамосвалд буцахад нь шигшин ангилах хэсгээс гарсан хаягдал шаврыг ачин уурхайн дотоод овоолгод нөхөн дүүргэлт хийхээр төсөлд тусгаж байна. Төслийн эхний жилд хөрсийг ил уурхайн урд хэсэгт нөөцгүй талбайд буюу уурхайн ханыг дагуулж хөрсний гадаад овоолго үүсгэн, ашиглагдсан хоосон орон зайг хөрс болон шигшин ангилах үйлдвэрээс гарах хаягдлаар дүүргэхээр төлөвлөсөн. Ил уурхайн блокыг ашиглаж дууссаны дараа ашиглагдсан орон зайд дотоод овоолго үүсгэж давхар техникийн нөхөн сэргээлтийн ажил хийж гүйцэтгэнэ.

***Хүснэгт 7. Гөлтгөнө олборлолтын ажлын тээвэрт ажиллах автосамосвалын техникийн тодорхойлолт***

№	Үзүүлэлт	Х.н	Утга
1	Автосамосвал		NORTHBENZ ND3315
2	Даац	тн	30
3	Өөрийн масс	тн	16.5
4	Тэвшний багтаамж	м <sup>3</sup>	16
5	Дээд хурд	км/ца г	77
6	Хөдөлгүүрийн заасан чадал	мор/х үч	375
7	Эргэлтийн радиус	м	10.2
8	Тэвшний өргөн	м	2.2
9	Урт	м	6.5
10	Өргөн	м	2.5
11	Өндөр	м	3.43
12	Дугуйн томьёо	-	8x4
13	Дугуйн хэмжээ	-	12.00R20
14	Түлшний савны багтаамж	л	380
15	Дугуйн тоо	ш	12



***Хүснэгт 8. Гөлтгөнө олборлолтын тээвэрт ажиллах автосамосвалын бүтээл, хэрэгцээний тооцоо***

№	Үзүүлэлт	Х.н	1-р жил	2-р жил	3-р жил	4-р жил	5-р жил	6-р жил
1	Автосамосвалын ажлын төрөл		Гөлтгөнө	Гөлтгөнө	Гөлтгөнө	Гөлтгөнө	Гөлтгөнө	Гөлтгөнө
2	Тэвшний багтаамж	м <sup>3</sup>	16	16	16	16	16	16
3	Тээврийн зай, нэг талдаа	м	1,300	1,430	1,502	1,577	1,655	1,738
4	Ачаалах хугацаа /тэвш ашиглалт/	сек	250.33	250.33	250.33	250.33	250.33	250.33
5	Овоолцыг тооцох коэффициент		1.10	1.10	1.10	1.10	1.10	1.10
6	Экскаваторын мөчлөгийн хугацаа	сек	25.00	25.00	25.00	25.00	25.00	25.00
7	Чулуулгийн нягтралтыг тооцох коэффициент		0.90	0.90	0.90	0.90	0.90	0.90
8	Экскаваторын утгуур дүүргэлтийн коэффициент		0.93	0.93	0.93	0.93	0.93	0.93
9	Экскаваторын утгуурын багтаамж	м <sup>3</sup>	2.10	2.10	2.10	2.10	2.10	2.10
10	Автосамосвалын хөдөлгөөний хугацаа	сек	390.00	429.00	450.45	472.97	496.62	521.45
11	Ачаатай чиглэлд явах хугацаа	сек	234.00	257.40	270.27	283.78	297.97	312.87
12	Хоосон чиглэлд явах хугацаа	сек	156.00	171.60	180.18	189.19	198.65	208.58
13	Ачих буулгах цэгт сэлгээ хийх хугацаа	сек	75.00	75.00	75.00	75.00	75.00	75.00
14	Ачаа буулгах хугацаа	сек	50.00	50.00	50.00	50.00	50.00	50.00
15	<b>Автосамосвалын рейсийн хугацаа</b>	<b>сек</b>	<b>765.33</b>	<b>804.33</b>	<b>825.78</b>	<b>848.30</b>	<b>871.95</b>	<b>896.78</b>
16	Автосамосвалын бэлэн байдлыг тооцох итгэлцүүр		0.95	0.94	0.93	0.92	0.91	0.90

17	Цагийн бүтээл	м <sup>3</sup>	71.50	67.32	64.87	62.47	60.11	57.81
18	Цагийн бүтээл	тн/цаг	157.30	148.09	142.71	137.43	132.25	127.18
19	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12.00	12.00	12.00	12.00	12.00	12.00
20	Цаг ашиглалтын итгэлцүүр		0.90	0.90	0.90	0.90	0.90	0.90
21	Автосамосвалын ээлжийн бүтээл	м <sup>3</sup>	772.19	727.01	700.59	674.66	649.23	624.31
22	Автосамосвалын ээлжийн бүтээл	тн/ээлж	1,698.81	1,599.43	1,541.31	1,484.25	1,428.30	1,373.49
23	Ээлжийн тоо	ээлж	2.0	2.0	2.0	2.0	2.0	2.0
24	Хоногийн бүтээл	м <sup>3</sup>	1,544.37	1,454.02	1,401.19	1,349.32	1,298.46	1,248.63
25	Жилд ажиллах хоног	хоног	90.00	90.00	90.00	90.00	90.00	90.00
26	Жилийн бүтээл	м <sup>3</sup>	138,993.74	130,862.10	126,106.90	121,438.75	116,860.95	112,376.54
27	Жилийн бүтээл	тн/жил	305,786.23	287,896.62	277,435.17	267,165.25	257,094.10	247,228.40

#### 1.4.4 Хөрсний чулуулгийг овоолох процесс

Уурхайн хөрсийг гадаад болон дотоод овоолгод байршуулах ба нийтдээ 718.18 мян.м<sup>3</sup> хөрс, сийрэгжсэн байдлаар 861.82 мян.м<sup>3</sup> хөрс овоолно гэж төсөлд тусгав.

Хөрсний овоолгод ажиллах утгуурт ачигчийн хүчин чадлыг жилд гадаад болон дотоод овоолгод ирэх хөрсний хэмжээнээс хамааруулан сонгосон бөгөөд Luigong-856 маркийн утгуурт ачигчийг сонгосон.

Уурхайн гадаад овоолгод Luigong-856 маркийн утгуурт ачигч ажиллах бөгөөд утгуурт ачигчийн жилд хийх ажлын хэмжээ нь уурхайн ухашны ханыг дагуулж овоолсон хөрсний чулуулгийн хэмжээгээр тодорхойлогдоно.

Уурхайн гадаад овоолгыг захлах хэлбэрээр овоолох ба дотоод овоолгыг ашиглалт явуулж дууссан талбайн хажуу руу буулгана. Уг тооцоо судалгаанд үндэслэн бульдозерын бүтээл, хэрэгцээний тооцоог хийж үзэхэд 1 ширхэг Luigong-856 маркийн утгуурт ачигч ажиллахад хүрэлцэхээр байна.

#### *Хүснэгт 9. Хөрс хуулалтын ажилд ажиллах LUIGONG 856 маркийн утгуурт ачигчийн техникийн үзүүлэлт*

№	Үзүүлэлт	Х.нэгж	Утга
1	Дугуйт ачигчийн марк		Luigong-856
2	Утгуурын багтаамж	м <sup>3</sup>	3
3	Өөрийн жин	тн	24.5
4	Зүтгэх хүч	кН	218
5	Асгалтын хамгийн их өндөр	м	3.15
6	Урт	м	9.11
7	Өргөн	м	2.96
8	Өндөр	м	3.6
9	Эргэлтийн радиус	м	7.2
10	Дээд хурд	км/ц	36.5
11	Шатахууны савны хэмжээ	л	410
12	Дугуйн тоо	ш	4
13	Дугуйн марк	-	26.5-R25



#### *Хүснэгт 10. Хөрс хуулалтын ажилд ажиллах LUIGONG 856 маркийн утгуурт ачигчийн бүтээлийн тооцоо*

№		Үзүүлэлт	Х.нэгж	Хөрс
1		Мөргөцөгт ажиллах дугуйт ачигчийн марк	-	Luigong-856
2	<i>tm</i>	Циклийн хугацаа	сек	30.29
3	<i>tay</i>	Ачаатай явах хугацаа	сек	14.29
4	<i>txy</i>	Хоосон явах хугацаа	сек	8.00
5	<i>tym</i>	Утгах хугацаа	сек	5.00

6	<i>txя</i>	Асгах хугацаа	сек	3.00
7	<i>Лу</i>	Сэлгээ хийж шилжих нэг талын зай	м	20.00
8	<i>Uад</i>	Ачаатай үеийн дугуйт ачигчийн хөдөлгөөний дундаж хурд	м/с	1.40
9	<i>Uхд</i>	Хоосон үеийн дугуйт ачигчийн хөдөлгөөний дундаж хурд	м/с	2.50
10	<i>Et</i>	Утгуурын багтаамж	м <sup>3</sup>	3.00
11	<i>Оц.уа</i>	Дугуйт ачигчийн цагийн бүтээл	м <sup>3</sup> /цаг	196.55
12	<i>Оэ.уа</i>	Дугуйт ачигчийн ээлжийн бүтээл	м <sup>3</sup> /ээлж	2,358.59
13		Дугуйт ачигчийн бэлэн байдлыг тооцох итгэлцүүр	-	0.95
14	<i>Куч</i>	Операторын ур чадварыг тооцох итгэлцүүр	-	0.95
15	<i>Кхя</i>	Хаягдлыг тооцох итгэлцүүр	-	0.95
16	<i>Кца</i>	Утгуурт ачигчийн цаг ашиглалтын итгэлцүүр	-	0.90
17	<i>Кс</i>	Чулуулгийн сийрэгжилт	-	1.40
18	<i>Тэ</i>	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12.00
19	<i>N</i>	Ээлжийн тоо		2
20	<i>Ох.уа</i>	Дугуйт ачигчийн хоногийн бүтээл	м <sup>3</sup> /хоног	4,717.18
21	<i>Оуа.ж</i>	Жилийн бүтээл	м <sup>3</sup> /жил	424,546.22

#### 1.4.4 Утгуурт ачигчийн бүтээлийн тооцоо

Ил уурхайгаас олборлосон гөлтгөнийг уриншлах талбай руу тээвэрлэн овоолго үүсгэн, уриншлан бэлтгэсэн гөлтгөнийг шигшин ангилах хэсэгт гөлтгөнийн агуулахад хураана хураана. Автосамосвалаар тээвэрлэж овоолсон гөлтгөнийг овоолгоос Luigong 856 маркийн 3 м<sup>3</sup> утгуурын багтаамжтай дугуйт ачигчаар зөөнө. Утгуурт ачигч овоолго дээр ажиллахаас гадна гөлтгөнө уриншлах талбай, бутлан ангилах хэсэг, зам талбай, шимт хөрсийг түрж овоолох зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

#### *Хүснэгт 11. Гөлтгөнө уриншлах ажилд ажиллах Luigong 856 маркийн утгуурт ачигчийн техникийн тодорхойлолт*

№	Үзүүлэлт	Х.нэгж	Утга
1	Дугуйт ачигчийн марк		Liugong-856
2	Утгуурын багтаамж	м <sup>3</sup>	3
3	Өөрийн жин	тн	24.5
4	Зүтгэх хүч	кН	218
5	Асгалтын хамгийн их өндөр	м	3.15
6	Урт	м	9.11
7	Өргөн	м	2.96
8	Өндөр	м	3.6
9	Эргэлтийн радиус	м	7.2
10	Дээд хурд	км/ц	36.5
11	Шатахууны савны хэмжээ	л	410
12	Дугуйн тоо	ш	4
13	Дугуйн марк	-	26.5-R25



#### *Хүснэгт 12. Гөлтгөнө уриншлах ажилд ажиллах Luigong 856 маркийн утгуурт ачигчийн бүтээлийн тооцоо*

№		Үзүүлэлт	Х.нэгж	Гөлтгөнө
1		Мөргөцөгт ажиллах дугуйт ачигчийн марк	-	Liugong-856
2	<i>tm</i>	Циклийн хугацаа	сек	30.29
3	<i>тая</i>	Ачаатай явах хугацаа	сек	14.29
4	<i>txя</i>	Хоосон явах хугацаа	сек	8.00
5	<i>тут</i>	Утгах хугацаа	сек	5.00
6	<i>txя</i>	Асгах хугацаа	сек	3.00
7	<i>Лу</i>	Сэлгээ хийж шилжих нэг талын зай	м	20.00
8	<i>Uад</i>	Ачаатай үеийн дугуйт ачигчийн хөдөлгөөний дундаж хурд	м/с	1.40
9	<i>Uхд</i>	Хоосон үеийн дугуйт ачигчийн хөдөлгөөний дундаж хурд	м/с	2.50
10	<i>Et</i>	Утгуурын багтаамж	м <sup>3</sup>	3.00
11	<i>Оц.уа</i>	Дугуйт ачигчийн цагийн бүтээл	м <sup>3</sup> /цаг	196.55


12	Оэ.уа	Дугуйт ачигчийн ээлжийн бүтээл	м3/ээлж	2,358.59
13		Дугуйт ачигчийн бэлэн байдлыг тооцох итгэлцүүр	-	0.95
14	Куч	Операторын ур чадварыг тооцох итгэлцүүр	-	0.95
15	Кхя	Хаягдлыг тооцох итгэлцүүр	-	0.95
16	Кца	Утгуурт ачигчийн цаг ашиглалтын итгэлцүүр	-	0.90
17	Кс	Чулуулгийн сийрэгжилт	-	1.40
18	Тэ	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12.00
19	N	Ээлжийн тоо		2
20	Ох.уа	Дугуйт ачигчийн хоногийн бүтээл	м <sup>3</sup> /хоног	4,717.18
21	Оуаж	Жилийн бүтээл	м <sup>3</sup> /жил	424,546.22

#### 1.4.4 Ухаж, ачих тоног төхөөрөмжийн сонголт, бүтээлийн тооцоо

“Тарагт-1”-ын гөлтгөний ордыг олборлох ил уурхайн гөлтгөнийг экскаватор, өөрөө буулгагч автосамосвалуудын хосолсон тээвэртэй ашиглалтын системээр ашиглах бөгөөд ухаж, ачих тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг дараах хүснэгтүүдэд үзүүлэв.

*Хүснэгт 13. HYUNDAI R320LC маркийн экскаваторын техникийн тодорхойлолт*

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Хөрс	Гөлтгөнө
			HYUNDAI 320	HYUNDAI 320
1	Утгуурын багтаамж	м <sup>3</sup>	2.10	2.1
2	Утгалтын түвшин дэх хамгийн их радиус	м	11.25	11.25
3	Утгалтын хамгийн их гүн	м	6.37	6.37
4	Ачилт хийх хамгийн их радиус	м	11.55	11.55
5	Ачилтын хамгийн их өндөр	м	7.75	7.75
6	Арын эргэлтийн радиус	м	4.78	4.78
7	Хөдөлгүүрийн чадал	кВт	193.1	193.1
8	Явах хурд	км/цаг	4	4
9	Масс	тн	32.2	32.2
10	Явах эд ангийн овор хэмжээ			0



*Хүснэгт 14. Гөлтгөнө олборлолт болон хөрс хуулалтын ажилд ажиллах экскаваторын бүтээлийн тооцоо*

№		Үзүүлэлт	Х.н	HYUNDAI 320	HYUNDAI 320
1		Ашиглалтын жил		1-7-р жил	
2		Экскаваторын ажлын мөргөцөг		Хөрс	Гөлтгөнө
3		Утгуурын багтаамж	м <sup>3</sup>	2.1	2.1
4	Аор	Экскаваторын орлын өргөн	м	19.1	19.1
5	Руг	Утгалтын түвшин дэх радиус	м	11.3	11.3
6	γ	Чулуулгийн эзлэхүүн жин	тн/м <sup>3</sup>	2.1	2.2
7	пор	Экскаваторын орлын тоо	тоо	2.0	2.0
8	тэм	Циклийн хугацаа	сек	25.0	25.0
9	тэр	Эргэх хугацаа	сек	8.5	8.5
10	ту	Утгах хугацаа	сек	5.0	5.0
11	тас	Асгах хугацаа	сек	3.0	3.0
12	Куд	Утгуур дүүргэлт		0.93	0.93
13	Кэт	Экскаваторын төрлийг тооцох итгэлцүүр		0.90	0.90
14	Ктх	Техникийн бэлэн байдлын итгэлцүүр		0.95	0.95
15		Чулуулгийн хаягдлыг тооцох коэффициент		0.9	0.9
16	Кус	Утгуур дахь чулуулгийн сийрэгжилт итгэлцүүр		1.20	1.10
17	Км	Мөргөцгийн нөхцөл тооцох итгэлцүүр		0.9	0.9
18	Коп	Операторын ур чадварын итгэлцүүр		0.9	0.9

19	Qтe x	Экскаваторын техникийн бүтээл 1 цаг	м <sup>3</sup> /цаг	141.1	154.0
20	Qэ ц	Экскаваторын техникийн бүтээл 1 цаг	тн/цаг	297.8	338.7
21	Кэц	Ээлжийн цаг ашиглалтын итгэлцүүр		0.90	0.90
22	Тэ	Ээлжинд ажиллах хугацаа	цаг	12.0	12.0
23	Ктх	Экскаваторыг тэврээр хангах нөхцөл тооцох итгэлцүүр		0.90	0.90
24	Км а	Мөргөцөг дахь ахилт шилжилтийг тооцох итгэлцүүр		0.95	0.95
25	Qээ	Ээлжийн бүтээл	м <sup>3</sup> /ээлж	1,303.3	1,421.7
26	Qээ	Ээлжийн бүтээл	тн/ээлж	2,749.9	3,127.8
27	пэ	Ээлжийн тоо		2.0	2.0
28	Qэх	Хоногийн бүтээл	м <sup>3</sup> /хоног	2,606.5	2,843.5
29		Жилд ажиллах хоног /Техникийн/	хоног	90.0	90.0
30	Qэ ж	Жилийн бүтээл /Техникийн/	м <sup>3</sup> /жил	234,585.8	255,911.8
31	Qэ ж	Жилийн бүтээл /Техникийн/	тн/жил	494,976.05	563,005.94
32		Автосамосвалын тэвшний багтаамж	м <sup>3</sup>		16.00
33		Утгалтын тоо	м <sup>3</sup>		7.6

#### 1.4.5 Зам засвар замын ашиглалт, үйлчилгээний ажил

Зам засвар, замын ашиглалт, үйлчилгээний ажлын бүрэлдэхүүнд замыг тэгшлэх, замын бартаа саадыг арилгах, замын эвдрэлийг засах, халтиргаа гулгаа үүсэхээс хамгаалж зам дээр элс цацах, , замыг шар усны үерээс хамгаалах зэрэг ажлууд орно.

Орон нутгийн уур амьсгал, замын хөдөлгөөний эрчим, тухайн замын тоосжилтын байдлаас хамааран замын тоосыг дарах ажлыг 5-8 сар буюу дулааны улиралд ээлжинд 4 удаа явуулна. Усны машин нь тодорхой чиглэлийн дагуу явж замын тоосыг дарж ус шүршинэ. Шаардлагатай тохиолдолд замын хэсэгчилсэн тоос дарах ажиллагааг хэрэгжүүлнэ. Хэрэв цаг агаар, хөдөлгөөний эрчмийн байдлаас шалтгаалан тоосжилт ихэсвэл замын тоос дарах ажиллагааг дахин давтан хийнэ. Замын тоосыг дарах ажиллагаанд Sinotruck үйлдвэрийн RHD SINOTRUK загварын усны машиныг сонгов.

Хүснэгт 15. Усны машины техникийн тодорхойлолт


№	Үзүүлэлт	Х.н	Утга
1	Загвар		RHD SINOTRUK
2	Өөрийн жин	тн	31.00
3	Усны савны багтаамж	тн	30
4	Усны машины бүтээл	м <sup>3</sup> /цаг	60
5	Дээд хурд	км/цаг	95
6	Хөдөлгүүрийн заасан чадал	кВт	380
7	Овор хэмжээ		
8	Урт	м	10.12
9	Өргөн	м	2.49
10	Өндөр	м	3.2
11	Дугуйн томьёо	-	6x4
12	Дугуйн хэмжээ	-	12.00-R20
13	Түлшний төрөл		Дизель
14	Түлшний савны багтаамж	л	400
15	Дугуйн тоо	ш	10



1.4.5 Уурхайн авто замын арчилгаа

Ил уурхайн авто замын арчилгааг тогтмол хийж байх нь тээврийн тоног төхөөрөмжийн бүтээлд эерэг нөлөө үзүүлэхээс гадна тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдлыг хангаж байдаг давуу талтай.

Уурхайн замыг дулааны улиралд тогтмол усалж гадаргууг чийглэж тоосжилтыг багасгах шаардлагатай. Мөн хүйтний улиралд замын гадаргуу мөстөх, халтиргаа гулгаа үүсэх зэрэг нөлөөллүүд үүсэхээс урьдчилан сэргийлэх ажлуудыг зохион байгуулах шаардлагатай юм.



Зураг 3. Төлөвлөж буй тээврийн зам

Иймд уурхайн замын гадаргууг тогтмол хусах, арчлах арга хэмжээг утгуурт ачигч ашиглан гүйцэтгэхээр ТЭЗҮ-д тусгалаа.

**Хүснэгт 16. Тоног төхөөрөмжийн жагсаалт**

№	Тоног төхөөрөмжийн төрөл	Марк	Хэмжих нэгж	Хүчин чадал	Тоо, ширхэг /тооцооны/
1	Усны машин	Sinotruck RHD SINOTRUK	тн	30	1
2	Тулшний машин	Dongfeng 5CBM	л	5000	1
3	Экскаватор	HYUNDAI R320LC	м <sup>3</sup>	2.1	1
4	Автосамосвал	NORTHBENZ ND3315	м <sup>3</sup>	16.00	1
5	Утгуурт ачигч	Liugong-856	м <sup>3</sup>	3.00	2
<b>Нийт</b>					<b>5</b>

**1.5 Гадаад тээвэр**

Ил уурхайгаас олборлох гөлтгөнийг уурхайн баруун талд байрлах уриншуулах талбайд байрлах гөлтгөний агуулахад хуримтлуулан тухайн талбайгаас Налайх дүүрэг хүртлэх 440 орчим км зайд гадаад тээвэр хийнэ.

Уурхайн талбайгаас олборлосон гөлтгөнийг 100 орчим км сайжруулсан шороон замаар тээвэрлэх бол 340 км хатуу хучилттай замаар тээвэрлэх юм.



**Зураг 4. Гадаад тээврийн замын трасс**

## 2. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ, ТҮҮНИЙ ҮНЭЛГЭЭ

### 2.1 Төслийн газарзүйн байрлал

“Эко Драйволл” ХХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайнууд нь засаг захиргааны хувьд Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт Улаанбаатар хотоос баруун урд зүгт 450 км, Дэлгэрхангай сумын төвөөс баруун урд зүгт 36 км, Хулд сумын төвөөс баруун зүгт 88 км-ийн зайд байрлана. Тарагт-1 ордоос Хулд сумын төв хүртэл ердийн шороон замаар холбогдох бөгөөд Хулд сумын төвөөс Улаанбаатар хот хүртэл холбосон хатуу хучилттай замтай. Ордын төв цэгийн солбицол Уртраг 104°29'38.5" Өргөрөг 45°02'41.5" байршина.

### 2.2 Уур амьсгалын үндсэн үзүүлэлтүүд

Энэ бүсэд Монгол орны тоосжилттой бүсийн районд хамрагдах бөгөөд, энэ нь уурхайн үйл ажиллагаа, тээвэрлэлтийн замуудтай шууд холбоотой гэж үздэг. Мөн сүүлийн жилүүдэд хур бороо хомс, өвс ургамлын гарц муу байсан нь хөрс ихээр хуурайших, салхины хурднаас үүсэх тоос шороо ихсэх нь тоос үүсэх нөхцөл бүрэлдэж байсан бөгөөд энэ жилийн хувьд цаг агаарын таатай уур амьсгалтай ургамал гарц сайн чийг хангалттай байгаа нь харьцангуй тоосжилт бага байна. Дэлгэрхангай сум нь манай орны хуурай, хуурайдуу говь цөлийн бүсэд багтдаг, хуурай уур амьсгалтай жилдээ 95,0 мм орчим тунадас унадаг, жилийн дундаж температур нэмэх 35°C градус, хүчтэй салхи, шороо шуурга олонтой болдог.

Уул уурхайн үйл ажиллагаа нь жилийн дөрвөн улирлын уур амьсгалын өөрчлөлтөөс шууд хамааралтай бөгөөд Дэлгэрхангай сумын нутаг нь дулааны улирал харьцангуй удаан үргэлжилдэг, хүйтэн улирлын үргэлжлэх хугацаа буюу хүйтэн, жавартай байх хугацаа Хангай нутгийг бодвол богино байдаг нь хээрийн нөхцөлд үйлдвэрлэл явуулахад тохиромжтой гэж үзэж болно.

### 2.3 Төсөл хэрэгжих орчны гадаргын усны төлөв байдал

Тус талбай нь ус зүйн хувьд Төв азийн гадагшаа урсгалгүй ай савын бүсэд багтдаг. Энэ ай савд хур тунадас харьцангуй бага, ууршилт их учраас гол мөрний сүлжээ маш бага бөгөөд нэгж талбайд ноогдох голын нийлбэр урт нь 0.01 км/км<sup>2</sup> -ээс доош байдаг. Эндэх гол мөрний үндсэн онцлог бол уулсаас гарангуутаа дотоодын аль нэг хотгор руу чиглэхдээ уурших юм уу, хөвсгөр зузаан хурдсанд шургах замаар ширгэж замхардагт оршино. Тухайн жил, улирлын цаг уур, хур тунадасны хэмжээнээс хамаарч усны горим ихээхэн хувьсамтгай, заримдаа гандаж ширгэдэг байна. Гол мөрний нийлбэр урсац 5мм-ээс доош байна. Харин гадаргын урсац нь болон газар доорх урсац нь 5мм-ээс доош, жилийн дулаан үеийн ууршилт 1000мм-ээс дээш

хэмжээтэй. Гол мөрний усны горимын хувьд зуны хур борооны усаар үерлэдэг сайр их тогтдог. Үүнд газар доорх ус 10%, хур борооны ус 90%-ийг эзэлдэг. Уг сайрууд нь хэдэн зуун метрээс хэдэн арван км үргэлжлэлдэг. Цас их орж хайлах, үргэлжилсэн бороотой үед эдгээр сайрууд урсгалтай болж бороо татрахад усгүй хуурай болно. Шар усны үерийн хамгийн их урсац нь Тост уул орчмоор 10-50мм бусад хэсгээрээ 10-аас доошгүй хэмжээтэй байдаг. Хур бороотой үед жижиг хонхор, хотгор газарт жижиг нуурууд бий болох ба тэдгээр нь элс, булингартай усаар дүүрч, хэдэн долоо хоног, хэдэн сар ч устай байдаг байна. Хүн малын ундаанд худгийн ус хэрэглэх бөгөөд худгуудыг голчлон дөрөвдөгчийн хурдсанд хуурай сайр, нуурын зах хавийг бараадуулан гаргасан байдаг. Худгийн түвшин нь 1-2 метр, заримдаа 5-7 метрт байдаг.

#### **2.4 Төсөл хэрэгжих орчны хөрсөн бүрхэвч**

Тус төслийн эзэмшил талбай нь хөрс- газарзүйн мужлалаар хөрс био-уур амьсгалын Говийн их мужийн Өргөргийн бүсшилийн хэв шинж бүхий цөлийн бор саарал хөрсний бүс 15-р тойрогт хамрагдана. Зонхилох хөрсний тархалтын хувьд газрын гадарга болон уур амьсгалын ерөнхий зүй тогтлыг даган төслийн талбайд элбэг тархалттай эгц уулс, шовх оройтой, хад асга бүхий газраар уулын цөлөрхөг хээрийн цайвар бор хөрс, уулын заримдаг цөлийн бор хөрс, Ү хэлбэрийн олон тооны гуу жалга, хавцлуудаар эрчимтэй хэрчигдсэн газраар жалга сайрын сул хөгжилтэй хөрс, нам уулс ба уулын хажуугийн тэгшивтэр бэл, хөндийгөөр цөлөрхөг хээрийн цайвар бор хөрс өргөн тархалттай байна.

#### **2.5 Төсөл хэрэгжих орчны ургамлан нөмрөг**

Монгол орны физик газарзүйн мужлалаар энэ хэсэгт Тарагт-1 төслийн талбайд уурхайн үйл ажиллагаа, ашиглалтын хугацаанд ургамлан нөмрөг тодорхой хэмжээгээр талхлагдах, доройтож болзошгүй тул төсөл хэрэгжих талбайн ургамлын нөмрөгийн төлөв байдлын судалгааг хийж гүйцэтгэв.

Төслийн үйл ажиллагаа явуулах талбай нь биогеографийн мужлалаар Евразийн хээрийн муж, Евразийн хээрийн их муж, Эрдэнэдалай-Мандалговийн тойрогт хамаарагдана (Юнатов, 1977). Байгалийн бүс бүслүүрийн хувьд Заримдаг цөлийн хээржүү цөлийн тойрогт хамаарагдана.

#### **2.6 Төсөл хэрэгжих орчны амьтны аймаг**

Тус бүс нутагт Монгол улсын хэмжээнд устаж болзошгүй зэрэглэлд багтах гурван зүйл амьтан (Аргаль хонь, Хулан адуу, Цагаан зээр), эмзэг зэрэглэлд багтах хоёр зүйл амьтан (Хар сүүлтий, мануул мий), ховордож болзошгүй зэрэглэлд багтах Янгир ямаа, Хярс зэрэг амьтад тархсан байна.

Амьтны тухай хуулиар 28 зүйл амьтан “нэн ховор”, Засгийн газрын 2012 оны 07 дугаар тогтоолоор 76 зүйл амьтан “ховор” амьтны жагсаалтад бүртгэгдээд байна. Амьтны амьдрах орчинд учруулж байгаа дарамт, ашиглалтын улмаас хөхтөн амьтдын зүйлийн 16% нь бүс нутгийн хэмжээнд устах аюултай, 2% нь устаж байгаа, 11% нь устаж болзошгүй, 3% нь эмзэг буюу байгальд устах эрсдэл өндөр, шувуудын зүйлийн 4% нь тоо толгой буурсан, нэн ховор, ховор ургамлын зүйлийн 11% нь устаж байгаа, 26% нь устаж болзошгүй, 37% нь эмзэг буюу байгальд устах эрсдэл өндөр, 15% нь ховордож болзошгүй байна.

### **2.7 Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн тусгай хамгаалалттай газар нутаг**

Монголчууд эрт дээр үеэс байгалийн үзэсгэлэнт газар, ховор амьтнаа дархлан хамгаалж, онголон тахиж ирсэн өнө эртний хосгүй уламжлалтай билээ. Энэ асуудлыг төрийн бодлогодоо тусгаж өндөр ач холбогдол өгдөг байсны илрэл нь Чингис хааны “Их засаг” хууль, Ойрадын цааз болон 16-р зууны үеийн хууль цаазат бичиг “Халх журам” зэрэг Монгол улсын хууль тогтоомжуудад нарийн тусгасан явдал юм. Төсөл хэрэгжих “Эко Драйволл” ХХК-ийн Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутаг дэвсгэрт орших “Тарагт-1” нэртэй талбай нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн бүсчлэлд хамааралгүй байна. Төслийн талбайгаас хойд зүгт 20.3 км зайд Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт орших Дэлгэрхангай уул байгалийн цогцолборт газрууд хамгийн ойр оршдог.

## **3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**

“Тарагт-1” төслөөс Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл нь:

1. Тоосжилт, хорт хийн ялгаралтаас үүдэх дуу шуугиан гэх мэтээс шалтгаалан төсөл хэрэгжих орчны айл өрхийн амгалан тайван байдал алдагдаж, эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлж болзошгүй.
2. Ил аргаар олборлолт явуулах, гадаад овоолго үүсгэх, тээвэрлэлтийн зам засах, холбогдох барилга байгууламж барих зэргээр газрын гадарга, хэвлийд нөлөөлнө.
3. Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийн эх үүсвэр нь уурхайн олборлолтын үйл ажиллагаа, овоолго үүсгэх, дотоод болон гадаад тээвэрлэлтээс үүсэх тоосонцор, төслийн бүхий л барилга байгууламжууд, ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдал, хүн, техникийн нөлөөгөөр ургамлан нөмрөг устах буюу доройтолд орно.

#### **4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2026 ОНЫ ГОЛ ЗОРИЛТ**

Дундговь аймгийн Дэлгэрхангай суманд орших “Эко Драйволл” ХХК-ийн Тарагт-1 гөлтгөнийн уурхайн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа БОАЖ-н сайдын 2019 оны 10 сарын 29-ний өдрийн А-618 тушаалаар батлагдсан

“Байгаль орчны менежмент төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-г баримталсан. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгалийн нөөц баялгийг ашиглах явцад байгаль орчныг доройтохоос урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хариуцах этгээд, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгасан. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төсөл хэрэгжүүлэх явцад байгаль орчинд үүсэж болзошгүй өөрчлөлтийг хянах, шинжлэх объект, байршил, баримтлах стандарт, арга аргачлал, хугацаа, хариуцах этгээд, хяналт шинжилгээний үр дүнг тайлагнах талаар тусгахаар хуульчлагдсаныг баримтлан боловсруулав.

Энэхүү төлөвлөгөөний гол зорилтуудыг Гөлтгөнийн уурхайн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний зөвлөмж, тайлант оны байгаль орчны менежмент төлөвлөгөөний хэрэгжилт болон түүнийг тодорхойлж үнэлгээ өгсөн орон нутгийн холбогдох ажлын хэсгийн дүгнэлт, байгаль орчны төлөвлөгөөт аудитын зөвлөмж зэрэг баримт бичгүүд дээр үндэслэн тодорхойлов.

2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтууд нь дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг хуваарийн дагуу авч хэрэгжүүлэх
- Уурхайн үйл ажиллагааг орон нутгийн иргэн аж ахуй нэгж байгууллагад танилцуулах, тэдгээртэй санал бодлоо солилцож, нутгийн иргэдтэй хамтран ажиллах
- Компаниас боловсруулж, баталсан журам, зааварчилгааг өөрийн уурхайн онцлогт тохируулан амжилттай хэрэгжүүлэх

## 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

### 5.1 Агаар орчныг хамгаалах чиглэлээр хийгдэх ажлууд

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хүнд машин механизмаас Тоосжилт үүсэх	Замын тоос дарах усалгаа хийх	Уурхайн дотоод тээврийн зам, талбай	-	200,000	Нийт зам талбай	200,000	Тухай бүрд	MNS 5013:2009 Бензинээр ажилладаг хөдөлгүүртэй автомашин Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөх дээд хэмжээ MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 4585 :2016 Агаарын чанар,
2		Гадаад тээврийн машин механизмын хурдны хязгаар 40км/ц-аас хэтрэхгүй байхаар хязгаарлах зааварчилгаа өгч, тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах, засаж сайжруулах	Гадаад тээврийн зам	-	300,000	Нийт зам талбай	300,000	Жилийн турш	
3	Бүтээгдэхүүн тээвэрлэх явцад тоосжилт, бохирдол үүсэх	Тээврийн машины түүхий эд хучилтыг сайжруулах	Гөлтгөнө тээврийн машин	-	Ш	Тухай бүрд	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүрд	
<b>Нийт</b>							500,000		

### 5.2 Усан орчныг хамгаалах чиглэлээр хийгдэх ажлууд

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Уурхайн ус хэрэглээнээс газар доорх усны нөөцийн хомсдол үүсэх	Унд ахуй болон мод бут, ногоон байгууламжид ашиглаж буй усыг бүртгэж, зохистой хэрэглээнд хяналт тавих	Уурхайн хэмжээнд		100,000	Нийт зам талбай	100,000	Тухай бүрд	Усны тухай хууль, 4.3, 30.1.1, 30.1.2 зүйл заалт БОНХАЖ-н сайд, БХБ-н сайдын 2015 оны А-230/127 дугаар хамтарсан тушаал
2	Ус бохирдож улмаар хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Эрүүл ахуйн бүсийн дэглэм тогтоох, хэвшүүлэх, ойр орчныг цэвэрлэх, хог хаягдлаар бохирдуулахгүй	Малчны худаг			Нийт зам талбай	400,000	Жилийн турш	

		байх							
<b>Нийт</b>						500,000			

### 5.3 Хөрсний эвдрэл, элэгдэлд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Шимт хөрсийг технологийн дагуу хуулна.	Шимт хөрсийг стандартын дагуу арчлах	Уурхайн карьер орчимд болон Шимт хөрсний овоолго	га	200,000	-	200,000	Шимт хөрс хуулах үед	MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5859:2019 “Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ
2	Тээврийн хэрэгслүүд, Шатахууны агуулах Болон ШТС-аас шатах тослох материал (ШТМ) асгарсан тохиолдолд Орчны хөрсөн бүрхэвчийг Бохирдуулж болзошгүй	ШТМ шингээх зориулалтын материалыг шаардлагатай газруудад бэлэн байлгах.	Засвар үйлчилгээний талбайд	га	Үйл ажиллагааны зардлаас	-	Үйл ажиллагааны зардлаас	Жилд 1 удаа	
3	Газрын гадарга, хэвлий эвдрэх	Газар хөндөх зөвшөөрөл авах	Уурхайн хэмжээнд	га	200,000	-	200,000	Жилд 1 удаа	
<b>Нийт</b>							400,000		

### 5.4 Ургамлан бүрхэвч, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

**Зорилго:** Уурхайн орчны ургамлын зүйлийн бүрдэл, амьтны аймгийг хамгаалах уурхайн үйл ажиллагаанаас ургамал, амьтанд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулахад оршино

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт орших “Тарагт-1” нэртэй гөлтгөнийн уурхайн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ургамлан нөмрөг талхлагдах	Ургамлан бичиглэл 2 цэгт хийх	Уурхайн хэмжээнд	-	50,000	Нийт зам талбай	100,000	Тухай бүрд	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Амьтны тухай хууль
<b>Нийт</b>							100,000		

### 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2026 онд төлөвлөгөөгөөр гөлтгөнөтэй хурдас олборлолт 190.6 мян.м<sup>3</sup>, хөрс хуулалт 91.44 мян.м<sup>3</sup> үүнээс 6.94 мян.м<sup>3</sup> шимт хөрсийг гадаад овоолгод, үлдсэн хөрсийг дотоод овоолго болгон техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийхээр төлөвлөж байна.

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг	
	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>6</b>	<b>7</b>	<b>8</b>	<b>9</b>	
1	Техникийн нөхөн сэргээлт	Дотоод овоолго	га				Үйл ажиллагааны зардалд	Жилийн турш	MNS 5915:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал, MNS 5917:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт	
2	Биологийн нөхөн сэргээлт	Дотоод овоолго	га	2	-	4,040,000	8,080,000	Жилийн турш		
3	Тэрбум мод үндэсний хөдөлгөөн	Уурхайн ажилчдын хотхоны ойр мод тарих	-	ш	50	42,400	2,120,000	5-р сард		
<b>Нийт</b>							10,200,000			

## 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээ, биологийн олон янз байдлыг сайжруулах зорилтуудыг тогтоох	Ховор ан амьтдад биотехникийн арга хэмжээ авах	Дэлгэрхангай УТХГ	-	-	3,200,000.0	9-р сард	-
<b>Нийт</b>						3,200,000.0		

## 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“MV-000251” ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаартай “Тарагт-1” нэртэй гөлтгөнийн уулын хэсгийн дугаартай талбайд малчин өрхийн өвөлжөө, суурин байхгүй болно. Нөлөөллийн бүсэд малчин өрх байхгүй тул 2026 онд нүүлгэн шилжүүлэх талаар ямар нэгэн ажил хийгдэхгүй.

## 9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Эко Драйволл” ХХК нь ISO 45001:2018 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн олон улсын стандартыг нэвтрүүлээд байна. Уурхайн ажиллагсдын эрүүл мэнд, ашиглалтын үеийн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхэд оршино.

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Уурхайд ажиллаж буй ажилчид бэртэж, гэмтэх	Осол эрсдэлийн тухай нийт ажилчдад сургалт явуулах	Нийт ажилтан	2	150,000.0	150,000.0	Жилд 1 удаа	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
2		Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн анхан, давтан зааварчилгааг мөрдүүлж ажиллах	Нийт ажилтан	-	Үйл ажиллагааны зардлаас	Үйл ажиллагааны зардлаас	Үйл ажиллагааны турш	
3		Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, байгаль орчны хяналт мониторинг хийх	Уурхайн хэмжээнд	2	750,000	750,000	Үйл ажиллагааны турш	
4	Гал түймэр	Төслийн талбайд гал түймрээс сэргийлэх, эрсдэлийг бууруулах боломжтой арга хэмжээг авах	Уурхайн талбай дахь бүх барилга байгууламж	Шинээр суурилуулах, хугацаа нь дууссаныг цэнэглүүлэх	Үйл ажиллагааны зардлаас	Үйл ажиллагааны зардлаас	Үйл ажиллагааны турш	
5		ШТС-ын сав, тоног төхөөрөмж, шугам хоолойн битүүмжлэлд хяналт тавих		-	Үйл ажиллагааны зардлаас	Үйл ажиллагааны зардлаас	Үйл ажиллагааны турш	
<b>Нийт</b>						900,000		

## 10. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**Зорилго:** Уурхайн үйл ажиллагаанаас үүссэн шингэн болон хуурай хог хаягдлын нөлөөгөөр байгаль орчин бохирдохоос урьдчилан сэргийлэх, ямар нэгэн байдлаар бохирдсон тохиолдолд тухайн сөрөг нөлөөллийг хурдан хугацаанд арилгахад оршино.

Компанийн хэмжээнд мөрдөгдөж байгаа “Үйлдвэр уурхайн хог хаягдлын менежментийн төлөвлөгөө”-г дагаж мөрдөх ба Уурхайн хог хаягдал ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах журмын дагуу ажиллана.

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1	Энгийн хог хаягдал	Хог хаягдлын цэгт, ариутгал, халдваргүйжүүлэлт хийх	Хог хаягдлын цэгт	-	120,000	2	240,000	Үйл ажиллагааны туршид	“Хог хаягдлын тухай” хууль, “Энгийн хог Хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”, “Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам”
2		Хуванцрын хог хаягдлыг ангилан ялгах	Уурхайн хэмжээнд	-	Үйл ажиллагааны зардлаас	-	Үйл ажиллагааны зардлаас	Үйл ажиллагааны туршид	
3		Зам талбайд хийсэж гарсан хог хаягдлын цэвэрлэгээ зохион байгуулах	Уурхайн хэмжээнд	-	190,000	4	760,000	Үйл ажиллагааны туршид	
4		Дахин ашиглагдах хаягдлыг хоёрдогч түүхий эд авдаг аж ахуйн нэгж байгууллагад нийлүүлэх. /хуванцар сав, мод, төмөр/	Уурхайн хэмжээнд	-	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүрд	Үйл ажиллагааны зардлаас	Үйл ажиллагааны туршид	
5		Хог хаягдлын чиглэлээр ажилчдад сургалт орох	Уурхайн хэмжээнд	-	Үйл ажиллагааны зардлаас	-	Үйл ажиллагааны зардлаас	Үйл ажиллагааны туршид	
6	Аюултай хог хаягдал	Хаягдал тос болон бусад аюултай хог хаягдлыг цуглуулж гэрээт компанид нийлүүлэх	Уурхайн хэмжээнд	тонн	1,000,000	1	1,000,000	Үйл ажиллагааны туршид	
<b>Нийт</b>							2,000,000		

### 11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
<b>Усны хяналт шинжилгээ</b>								
1	Ca, Mg, CL, SO4, NO2, NO3, NH4, NCO3, Fe, As, Na, Cd, Cu, Pb, Zn, Cr, Ni, Ag, Al, B, Mn, Se, Sr, Mo, Co, Be, Sb-ийн агууламж, амт, үнэр, өнгө, рН нийт ууссан хатуу бодисын хэмжээ, нийт хатуулаг, цахилгаан дамжуулах чанар	Уурхайн худаг	3,7 -р сард	Жилд 2 удаа	100,000	200,000	-	Ундны ус Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ Газрын доорх ус бохирдуулагч бодис, элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ Усны чанар Гүний уснаас дээж авах зөвлөмж
2	Хүнд металл							
3	Бактериологи							
4	Усны түвшин хэмжилт хийх							
<b>Хөрсний шинжилгээ</b>								
	Хөрсний агрохимийн найрлага, механик бүрэлдэхүүний шинж чанар	Шимт хөрсний овоолго	4 болон 10-р саруудад	Жилд 1 удаа	100,000	100,000	-	Шинжилгээний дээж авах ерөнхий шаардлага MNS 5850:2008, Хөрсний чанар, хөрс бохирдуулагч элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга MNS ISO 10390, Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 2143:2000, хөрсний физик шинж чанарыг тодорхойлох лабораторийн арга
		Ажилчдын хотхон орчим						
		Технологийн зам						
		Уурхайн карьер						
		ШТС орчим						
	Хогийн цэг							
	Хөрсний хүнд металл (Cr, Cd, Pb, Ni, Zn агууламж)	Шимт хөрсний овоолго	4 болон 10-р саруудад	Жилд 1 удаа	100,000	100,000	-	
		Ажилчдын хотхон орчим						
		Технологийн зам						
		Уурхайн карьер						
		ШТС орчим						
	Хогийн цэг							
	Бактериологи	Хогийн цэг	4-р сард	Жилд 1 удаа	150,000	150,000	-	MNS 6341:2012 хөрсний чанар, хөрсөнд

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт орших “Тарагт-1” нэртэй гэлтгөнийн уурхайн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

							нян судлалын шинжилгээ хийх арга		
<b>Агаарын чанарын шинжилгээ</b>									
Тоосжилт PM(2.5), PM(10) Дуу шуугианы хэмжилт хийх	Технологийн зам	5,7,9,11-р саруудад	4 удаа	25,000	100,000	-	Агаарын чанар, Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2007 Агаарын чанар, Орчны агаарын хүхрийн ислийн агуулгыг тодорхойлох MNS ISO 4221:2002		
	Уурхайн карьер орчим								
	Ажилчдын хотхон								
	Уурхайн карьер								
SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> , CO	Уриншуулах талбай	9-р сард	Жилд 1 удаа	150,000	150,000	Мэргэжилийн байгууллагаар			
	Технологийн зам								
	Уурхайн карьер орчим								
	Ажилчдын хотхон								
Уурхайн карьер	Уриншуулах талбай	<b>Ургамалын судалгаа</b>							
		Уурхайн карьер	Уриншуулах талбай	Ургамал зүйлийн бүрдэл (овог, төрөл зүйл), бодгалийн тоо, дундаж өндөр, бүрхэц, үе шат, биомасс	Мониторингийн цэгт	5 болон 9-р сард	Жилд 1 удаа	300,000	100,000
<b>Нийт</b>									

## 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцоолсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан
			2026 он			
			сар	сар	сар	
1.	Нийт ажилтнуудад байгаль орчныг хамгаалах чиглэлээр сургалт зохион байгуулах	Үйл ажиллагааны зардлаас	3	-	-	Уурхайн дарга, БО-мэргэжилтэн
2.	Уурхайн ус ашиглах дүгнэлт гаргуулж зөвшөөрөл авах, гэрээ байгуулах, төлбөр төлөх	500,000	3	-	-	БО-мэргэжилтэн
3.	Уурхайн хог хаягдлын гэрээг хийж, төлбөр төлөх	Гэрээгээр	3	-	-	Гүйцэтгэх захирал
4.	Байгаль орчныг хамгаалах чиглэлээр орон нутаг болон иргэдтэй хамтран ажиллах санал санаачилгыг өөрийн нөхцөл боломжийн хүрээнд хэрэгжүүлэх	900,000	-	7	-	Уурхайн дарга, БО-мэргэжилтэн
	Нийт	1,400,000				

## 13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
1	“Эко Драйволл” ХХК	Уулзалт	2026 оны БОМТ-ний хэрэгжилт	2026 оны 11 сар	ҮАЗ	Уурхайн дарга, БО-мэргэжилтэн	2-р Багийн төвд

## 14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

2026 оны Байгаль орчныг хамгаалах ажилд 12,800,000.0 төгрөг, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 2,200,000 төгрөг бөгөөд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нийтдээ 15,000,000 төгрөг зарцуулна.

№	Хийгдэх ажлууд	Зардал, төг
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1,500,000
2.	Нөхөн сэргээлтийн ажил	10,200,000
3.	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардал	3,200,000
4.	Төслийн хаалтад хуримтлуулах зардал	2,500,000

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт орших “Тарагт-1” нэртэй гөлтгөнийн уурхайн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

5.	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд зарцуулах зардал	900,000
6.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд зарцуулах зардал	2,000,000
7.	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	1,400,000
8.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	900,000
Нийт		22,600,000